

The Baptist Tabernacle of Los Angeles

Mailing Address:
P. O. Box 15308
Los Angeles, CA 90015

Phone: (213) 744-9999

E-mail: rlhymersjr@sbcglobal.net

www.sermonsfortheworld.com

www.baptisttabernacle.com



Dr. Christopher L. Cagan
Pastor

Dr. R. L. Hymers, Jr.
Pastor Emeritus

Арван хоёрдугаар сар, 2020

Эрхэм анд минь:

Энэ 2020 оны турш сатаны тарьсан хог новш дундуур туучсан жил байна. Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх талаар шүүх хурал боллоо! Корона вирусын хөл хорио! Ой хээрийн түймэр манай их ойг шатаалаа! Хүмүүс Коммунистуудыг дагаж, галзуурч, манай хотуудыг шатааж байсан! Би өөрөө номлолын талбарт удаан зогсож чадахгүй болсон! “Зарим нь итгэлээс (урваж), мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн номлолд анхаарлаа хандуулна; хоёр нүүрт байдлаар худал ярьж; өөрсдийн мөс чанартаа халуун төмрөөр тамгалагдан хоёр нүүр гарган худал ярьж” (I Тимот 4:1, 2)! Бүр Поп лам хүртэл ижил хүйстний гэрлэлтийг зөвшөөрсөн! Энэ нь яг бүх дэлхий хэзээ язаагүй дэлбэрэхэд бэлэн болсон мэт санагдаж байна; Есүс ийнхүү хэлсэн,

“Нар, сар, одод дээр тэмдэг бий болж, тэнгисийн болон давалгааны хүрхрэх шуугианаас үүдэж газар дээрх үндэстнүүдийн дунд айдас төрнө. Тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдсэнээс болж дэлхийд ирж буй зүйлсийг тэд санаж, айснаасаа ухаан алдана. Дараа нь тэд хүч болон агуу сүр жавхлантайгаар үүлэн дээр залран ирэх Хүний Хүүг харна. Харин эдгээр нь биелж эхлэх үед цэх зогсож тэргүүнээ өргө. Учир нь та нарын золилт ойртож байна гэв.” (Лук 21:25-28).

“Харин та нарыг эцэг эх, ах дүүс, садан төрөл, анд нөхөд чинь хүртэл бариулна. Тэд заримыг чинь ална” (Лук 21:16).

Бид энэ үгийг хэрхэн уншиж, библийн эш үзүүлэлийн эцсийн өдрүүдэд яг одоо амьдарч буйгаа хэрхэн харахгүй байна вэ?

“Гэхдээ энэ Христмасын үе” гэж та нар хэлдэг! 1941 оны арванхоёрдугаар сард Япончууд Пийрл Харборыг бөмбөгдөж, Гитлер Лондоныг бөмбөгдөж байсан учраас Черчилл Англиас энд ирсэн байсан. Черчилл цагаан ордонд ерөнхийлөгч Франклин Д.Рузвелттэй уулзаж байсан. Ерөнхийлөгч улсынхаа Христмасын модны чимэглэлийг асаах үед Черчилл ийнхүү хэлсэн, “Хүүхдүүд зугаацан, тоглож наадаарай.”

Гэвч та бид бол “хүүхдүүд” байхаа больсон! Энэ бол бидний цорын ганц найдвар Бетлехемд мэндэлсэн нялх хүүд байхыг хүлээн зөвшөөрөх цаг үе юм – бидэнд жинхэнэ найдвар байхгүй ч гэсэн Хаадын Хаан, Эздийн Эзэн, дахин ирж буй Есүст байгаа!

Олон жилийн өмнө 1950-иад онд Бурхан надад энэ урвалт шарвалтын өдрүүдэд пастор байхад гүн туслалцаа үзүүлсэн нэгэн эшлэлийг өгсөн юм.

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13).

МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУДЫГ WWW.SERMONSFORTHEWORLD.COM-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.

Хоёрдугаар сарын 2-нд бид Хятадын цагаан сарыг өглөө болон оройн цуглаан дээрээ тэмдэглэсэн.

Гуравдугаар сарын 1-нд бид Хоёе Гудамж дахь хуучин байрандаа сүүлийн цуглаанаа хийсэн. Бид (2020) оны үлдсэн хугацаанд коронавирусын улмаас хоёр хаусанд цугларалтаа хийсэн. Долоо хоног бүр би хичээлээ бичлэг хийн хоёр хаусанд гаргадаг. Тэр видео сургаалийн дараа бид оройн хоол иддэг.

Миний 79 насны төрсөн өдөр дөрөвдүгээр сарын 12-ны өдөр Дахин амилалтын Ням гарагт тохиосон. Мөн бид миний эхнэрийн төрсөн өдрийг дөрөвдүгээр сарын 16-нд тэмдэглэсэн. Би "Олон эмэгтэйчүүд сайн үйл хийдэг ч чи тэднээс илүү билээ" (Сургаалт үгс 31:29) гэж хэлж чадна.

Есдүгээр сарын 27-нд чуулган бидний хуримын 38 дахь жилийн ойг тэмдэглэсэн. Өнгөрсөн оны хувьд би доод гэдэсний өвчний улмаас босоод үгийг дамжуулах боломжгүй болсон. Хавдарыг эмчилхээр хэт туяаны эмчилгээ нь мэдрэлийг устгаснаар энэхүү Кроны Өвчинтэй адил өвчин тусахад хүргэсэн.

Гэсэн ч тэр жилээ Бурхан бидний ажлыг ерөөсөн! Бид өөрсдийн www.sermonsfortheworld.com сайтад дахиад гурван хэлний үг бүрчлэн библи судлал болон номлолуудаа байрлуулсан. Бид Мянмар (Бирми) улсын Хонгсо Чин нутгийн хэл дээрхийг 43 дахь болгож нэмсэн. Мөн Энэтхэгийн өөр нэг хэл болох Малаяалам гэдгийг 44 дэхээр нь нэмсэн. Тэгээд дараа нь Шри Ланка улсын Синхала хэлийг 45 дахь хэлээр нэмсэн.

Долоо хоног бүр дэлхий даяарх номлогч нараас эдгээр хичээлүүд болон номлолууд нь тэдэнд хичнээн их тус болж буй талаар гайхалтай мэйлүүдийг хүлээн авч байгаа.

Долдугаар сарын 7-д манай Хоёе Гудамжны хуучин байшинд байсан гурван талын гэрээг сулласан бөгөөд үүн дээр ажилласан манай том хүү Робертод маш их баярлаж байгаа.

Аравдугаар сарын 13-нд бүх чуулганаараа Риверсайд Үндэсний Оршуулгын газарт болсон Еугене Грэйсийн амьдрал арга хэмжээнд оролцсон. Др Каган хатагтай Грэйсийг өөд болохоосоо хэдхэн цагийн өмнө нь Есүст итгэхэд нь хөтөлсөн. Ноён Грэйс бол манай чуулганы нэгэн сайхан залуугийн хойд аав нь байсан. Хэдэн долоо хоногийн дараа Др Каган ноён Грэйсийн эхнэр Софиед сайн мэдээг танилцуулсан бөгөөд одоо тэр мөнх амьтай болсон. Тэр найдвартайгаар манай Сан Габриел дэх шинэ байрлалд баптисм хүртсэн анхны хүн болох болно. Хатагтай Химерс намайг ноён Грэйсийн оршуулгын ёслолд дагуулж очсон. Дараа нь тэр намайг далайн эрэгт хэдэн өдөр амарсан Окснард руу дагуулж явсан.

Арваннэгдүгээр сарын 22-нд (Ням гараг) Др Каганы Алхамбра дахь гэрт Талархалын баяр тэмдэглэхээр төлөвлөөд байгаа. Би одоо ч гэсэн ажиллаж, номлол болон сургаалуудаа бичиж, Др Каганд тусалсаар байна. Хэдхэн долоо хоногийн дараа би 81 нас руугаа явж орох гэж байна. Хэрвээ миний гайхалтай гэргий Илеана байгаагүй бол би ийнхүү зогсолтгүй ажиллаж чадахгүй байх байсан – мөн би хүч чадал авдаг Есүс байгаа учраас би үргэлжлүүлсээр байна.

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13).

Энэ бол Есүсийн амлалт! Энэ захиагаа би миний хамтрагч болох Др Кристофер Л.Каганы гэрчлэлээс эш татан дуусгамаар байна:

Хэдэн жилийн өмнө надад амар тайван байгаагүй. Би өөрийнхөө төлөө амьдарч байсан. Би Бурханы талаар эсвэл үхэх үед юу болох талаар боддоггүй байсан. Би Бурханаас нуугдаж, зугтан амьдарсан. Би сургуульдаа А үнэлгээ авдаг, их мөнгө олдог байсан, гэсэн ч би ганцаардсан бөгөөд аз жаргалгүй нэгэн байсан.

Дараа нь би надад их сайхан хандсан хэсэг Христ итгэгч нартай уулзсан. Би чуулганд явж эхэлсэн. Гэсэн ч би өөрийн замаар амьдрахыг хүссээр байсан. Нэгэн орой би сургууль дээр болсон цуглаанд очсон. Нэгэн залуу надад миний

МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛТЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУДЫГ WWW.SERMONSFORTHEWORLD.COM-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.

өмнө хэзээ ч сонсож байгаагүй гайхалтай мэдээг хэлсэн – Бурхан надад хайртай бөгөөд надад мөнх амь өгөхийг хүсэж байгаа тухай. Тэр надад энэ амийг хэрхэн авахыг хэлж өгсөн. Тэр орой би Есүст итгэсэн. Тэр миний гэмийг уучилж, надад мөнх амийг өгсөн.

Одоо би амар тайван болсон. Одоо би мөнх амьтай. Есүс намайг дотроос минь эдгээсэн. Тэр надад найдвар хийгээд аз жаргалыг өгсөн. Би цаашид ганцаардахаа болисон. Энэ орой би үхвэл Есүс надад мөнх амь өгсөн учраас Тэнгэрийн улсад Бурхантай хамт байх болно гэдгээ би мэдэж байгаа!

Би Есүсийн төлөө ажиллаж байгаадаа үнэхээр талархаж байгаа! Би энэ бүгдийг Түүний хүч хийгээд нигүүлсэлгүйгээр, Др Каган, Илеана, дараагийн хавар судасны мэс засал болон үүнтэй холбоотой чиглэлээр дээд сургуульд сурах бидний хүү Жон Веслигүйгээр эдгээрийг би хийж чадахгүй байх байсан.

Есүс та нарыг болон танай гэр бүлийг ерөөх болтугай! Мөн Есүсээр аврагдах тухай Кент Пилпоттын номон дээр бид ажиллаж байгаа бөгөөд та бүхэн Кент болон миний төлөө залбирч өгөөрэй! Сан Габриел дахь Хятад Баптист Чуулгандаа шинээр эхлэхэд бидний төлөө залбирч өгөөрэй.



Др Химерс эхнэр Ил?ана, хүү Роберт, Робертийн эхнэр Жин, Робертийн хоёр нялх охид Ханна болон Сара нартай хамт. Тэд дахиад нэг хүүхэдтэй болохын төлөө нь би залбирч байгаа.

Христ үүрд магтагдах болтугай!

Р.Л Химерс Жр.,
D.Min., D.Rel., Th.D., Litt.D.
Филиппой 4:13

“Ухааны замаас төөрсөн хүн
үхэгсдийн цуглаанд байраа
эзэлнэ” (Сургаалт үгс 21:16).

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН
НОМЛОЛУУДЫГ WWW.SERMONSFORTHEWORLD.COM-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**